

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, даатгуулагч болон даатгагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Тариалангийн индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Даатгалтай холбоотой нийтлэг харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2. Тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-д зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.3. Тариалангийн индексжүүлсэн даатгалд тариаланч иргэн, хуулийн этгээд даатгуулж болно.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “алдагдлаас хамгаалах сан” гэж тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй санхүүгийн алдагдлыг шингээх, даатгагчийн төлбөрийн чадвар болон даатгалын тогтолцооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүрдүүлсэн нөөц санг;

4.1.2. “босго үзүүлэлт” гэж даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор тогтоосон, индексийн утгын өөрчлөлтөөс хамааран нөхөн төлбөрийг хувь тэнцүүлсэн эсхүл шаталсан байдлаар олгох түвшнийг;

4.1.3. “давхар даатгалын компани” гэж энэ хуулийн дагуу тариалангийн индексжүүлсэн даатгалын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.4. “даатгалын нэгж” гэж даатгагч, даатгуулагч нар харилцан тохирч гэрээнд заасан индексжүүлсэн даатгалд хамруулах таримлын төрөл, талбайн хэмжээ, байршил, тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, талбар, даатгалын хугацаагаар тодорхойлогдох, даатгалын үнэлгээ тогтоох суурь нэгжийг;

4.1.5. “даатгалын нөхөн төлбөр” гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн төлбөрийг;

4.1.6. “даатгалын тохиолдол” гэж тариалангийн индексийн үзүүлэлт нь энэ хууль болон даатгалын гэрээнд заасан босго нөхцөлийг хангасан байдлыг;

4.1.7. “даатгалын үнэлгээ” гэж даатгуулагчийн сонгосон даатгалын нэгжид ногдох бөгөөд даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох суурь үзүүлэлт болох мөнгөн дүнг;”

4.1.8. даатгалын хамрах хугацаа” гэж даатгалд хамрагдах тухайн төрлийн таримлын тариалалтаас ургац хураалт хүртэлх хугацаа болон Засгийн газраас тогтоосон бусад хугацааг;

4.1.9. “индекс” гэж хур тунадас, температур, хөрсний чийг, гангийн индекс, тариалангийн бүс дэх ургацын сумын дундаж индекс зэрэг тариалангийн эрсдэлийг төлөөлөх статистик үзүүлэлтийг;

4.1.10. “нөхөн төлбөрийн хүснэгт” гэж индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийг тооцох зорилгоор индексийн босго, өөрчлөлтийн түвшин бүрд харгалзах нөхөн төлбөрийн хувь, хэмжээ, дээд хязгаар, шаталсан болон хэсэгчлэн олгох нөхцөлийг урьдчилан тогтоосон хүснэгтэн илэрхийллийг;

4.1.11. “суурь зөрүү” гэж индексийн үзүүлэлт болон даатгуулагчид бодитоор учирсан хохирол хооронд бүрэн нийцэл үүсэхгүй байх эрсдэлийг;

4.1.12. “тариалангийн индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж даатгуулагчид учирсан бодит хохирлоор бус, даатгалын хамрах хугацаанд тухайн нэгжид тооцогдох индексийн үзүүлэлт босго хэмжээнээс давсан тохиолдолд нөхөн төлбөр олгох даатгалын үйл ажиллагааг;

4.1.13. “хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт” гэж индексийн мэдээлэл, холбогдох өгөгдлийг цуглуулах, хэмжих, түүнд үндэслэн тооцоолол хийж тайлагнах,

итгэмжлэгдсэн хараат бус хянан баталгаажуулагчийн дүгнэлтийг гаргуулсны үндсэн дээр даатгуулагч болон олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааны цогцыг;

4.1.14. “хамтын эрсдэлийн сан” гэж энэ хуулийн дагуу бүрдүүлэх эрсдэлийн дунд түвшний сан, эрсдэлийн дээд түвшний сан болон алдагдлаас хамгаалах сангийн нийлбэр зохион байгуулалтыг;

4.1.15. “эрсдэлийн дунд түвшний сан” гэж индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийн дагуу дунд түвшний эрсдэл үүссэн тохиолдолд олгох нөхөн төлбөрийг санхүүжүүлэх зориулалттай, даатгагчийн бүрдүүлэх нөөц хөрөнгө, эсхүл даатгагчдын хамтран бүрдүүлэх санг;

4.1.16. “эрсдэлийн дээд түвшний сан” гэж индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийн дагуу их хэмжээний, системийн шинжтэй эрсдэл үүссэн тохиолдолд олгох нөхөн төлбөрийг санхүүжүүлэх зориулалттай, давхар даатгалын компани болон/эсхүл төрийн оролцоотойгоор бүрдүүлэх санг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ЗАРЧИМ, БҮТЭЭГДЭХҮҮН, НЭГЖ

5 дугаар зүйл. Үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Тариалангийн индексжүүлсэн даатгал дараах зарчимд тулгуурлана:

5.1.1. сайн дурын, тэгш хүртээмжтэй байх;

5.1.2. индекс тооцох, нөхөн төлбөр олгох аргачлал нь шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод байх;

5.1.3. эрсдэлийг хуваарилах давхар хамгаалалттай байх;

5.1.4. суурь зөрүүний талаар даатгуулагчид урьдчилан мэдээлэх;

5.1.5. өгөгдлийн чанар, баталгаажуулалт, хараат бус хяналтыг хангах;

5.1.6. даатгуулагч, даатгагчийн эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, маргаан шийдвэрлэх тодорхой журамтай байх.

6 дугаар зүйл. Даатгалын хэлбэр, нэгж

6.1. Тариалангийн индексжүүлсэн даатгал нь дараах хэлбэртэй байна:

6.1.1. хур тунадас/гангийн индексэд суурилсан;

6.1.2. температур/халууны индексэд суурилсан;

6.1.3. хөрсний чийг, таримал ургамлын өсөлт, саатлыг зайнаас тандах индексэд суурилсан;

6.1.4. сумын дундаж болон тариалангийн талбайн ургацын индексэд суурилсан;

6.1.5. хоёр ба түүнээс дээш индексийн үзүүлэлтэд суурилсан даатгалын бүтээгдэхүүн.

6.2. Даатгалын хамрах нэгжийг дараах байдлаар тогтооно:

6.2.1. таримлын төрөл: даатгалын гэрээнд заасан таримлын төрөл;

6.2.2. талбайн байршил: газарзүйн мэдээллийн системд суурилан тариалангийн талбайн торон нэгж, эсхүл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж;

6.2.3. даатгалын хугацаа: даатгалын гэрээнд заасан тариалалтаас хураалт хүртэлх хугацаа.

6.3. Даатгуулагч нь даатгалд хамруулах талбайн эзэмших, ашиглах эрхийн баримт бичиг, эсхүл хууль ёсны ашиглалтын нотолгоог бүрдүүлнэ.

6.4. Даатгалд хамрагдах талбайг газар зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгэж, индексийн тооцоонд ашиглана.

6.5. Даатгуулах нэгжийн бүртгэл, кодчиллол, баталгаажуулалтын журмыг Засгийн газар батална.

6.6. Даатгалын нэгжийн ангилал, индексийн тохирлыг гурван жил тутам шинэчлэн тогтооно.

6.7. Энэ хуулийн 6.1-д заасан индексэд хамаарах боломжгүй мөндөр, хяруу, үер, цасан болон шороон шуурга, өвчин, хортон шавж, мэрэгчид зэрэг богино хугацаанд, бага талбайг хамарсан байгалийн гамшгийн эрсдэлийг Даатгалын тухай хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл. Даатгалд хамруулах таримал, үнэлгээ

7.1. Индексжүүлсэн даатгалд хамруулах таримлын нэр төрлийг даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож даатгалын гэрээнд тусгана.

7.2. тариалангийн бүсийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу сум эсхүл талбайг бүсчилж, тухайн нэгжид тохирох индексийг таримлын нэр төрлөөр сонгон хэрэглэнэ.

7.3. даатгалын үнэлгээг тухайн таримлын нэгж талбайд ногдох түүхэн дундаж ургац, даатгалын гэрээ байгуулах үеийн зах зээлийн дундаж үнэ болон даатгалын хамрах хувийг харгалзан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ИНДЕКСИЙН МЭДЭЭЛЭЛ, БОСГО ҮЗҮҮЛЭЛТ

8 дугаар зүйл. Индексийн мэдээллийн эх үүсвэр, нийтэд мэдээлэх

8.1. Индексийн тооцоонд ашиглах мэдээллийн эх үүсвэр нь дараах шаардлагыг хангана:

8.1.1. албан ёсны, тогтмол, шалгагдахуйц байх;

8.1.2. аргачлал нь нийтэд нээлттэй байх;

8.1.3. тухайн нэгжид төлөөлөхүйц нягтрал, чанартай байх.

8.2. Индексийн тооцоонд дараах эх үүсвэрийг ашиглана:

8.2.1. цаг уурын албан ёсны ажиглалтын мэдээлэл;

8.2.2. даатгуулагчийн өөрийн талбайдаа байршуулсан мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл;

8.2.3. үндэсний статистикийн байгууллагын ургацын мэдээлэл;

8.2.4. зайнаас тандан судлал, хиймэл дагуулын өгөгдөл;

8.2.5. баталгаажсан бусад агро-мэдээллийн систем.

8.3. Индексийн албан ёсны мэдээллийг статистик, цаг уур, газар тариалангийн мэдээллийн нэгдсэн тогтолцоогоор дамжуулан нийтэд мэдээлнэ.

8.4. Индексийн мэдээлэл цуглуулах, индекс тооцох, тайлагнах, нийтэд мэдээлэх болон хөндлөнгийн баталгаажуулалтыг хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоонд үндэслэн зохион байгуулна. Индексийн мэдээллийг нийтэд мэдээлэх давтамж, хэлбэр, баталгаажуулалтын журмыг Засгийн газар батална.

8.5. Индекс тооцох аргачлал, мэдээллийг баталгаажуулах, алдаа засах журмыг холбогдох төрийн байгууллага хамтран батална.

9 дүгээр зүйл. Босго үзүүлэлтийг тогтоох

9.1. Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах босго үзүүлэлтийг Засгийн газар тариалангийн бүс дэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, таримал ургамлын төрөл бүрээр дараах байдлаар тогтооно:

9.1.1. даатгуулагчийн өөрийн эрсдэл хүлээх нэгдүгээр босго;

9.1.2. даатгагч буюу хамтын сангийн эрсдэл хүлээх хоёрдугаар босго;

9.1.3. давхар даатгалын компани болон төрийн хамгаалалтын дээд түвшний босго.

9.2. Босго үзүүлэлтийг тогтоохдоо талбайн түүхэн өгөгдөл, уур амьсгалын эрсдэлийн зураглал, ургацын хэлбэлзэл, даатгалын хамрагдалт, хураамж/нөхөн төлбөрийн гүйцэтгэл зэргийг харгалзан үзнэ.

9.3. Босго үзүүлэлтийг жил тутам шинэчлэн тогтооно.

10 дугаар зүйл. Эрсдэлийн түвшин, нөхөн төлбөрийн шатлал

10.1. Босго үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн түвшнийг бага, дунд, дээд гэж ангилна.

10.2. Нөхөн төлбөрийг индексийн үзүүлэлтийн өөрчлөлтөөс хамааран дараах зарчмаар тооцож олгоно:

10.2.1. индексийн үзүүлэлт даатгалын тохиолдол гэж тооцох босгыг хангаж, түүнээс давсан хэмжээнээс хамааран нөхөн төлбөрийн хэмжээ шаталсан байдлаар нэмэгдэх;

10.2.2. индексийн үзүүлэлт эрсдэлийн дунд түвшний босго хэмжээнд хүрсэн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгох;

10.2.3. индексийн үзүүлэлт эрсдэлийн дунд түвшний босго хэмжээнээс нэмэгдсэн тохиолдолд нөхөн төлбөрийг хэсэгчлэн болон шаталсан байдлаар олгох;

10.2.4. нөхөн төлбөрийн нийт хэмжээ тухайн даатгалын нэгжид тогтоосон даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй дээд хязгаартай байх.

10.3. Индексийн үзүүлэлтийн өөрчлөлтөөс үүдэн бодит хохиролтой бүрэн нийцэхгүй байх эрсдэлийг бууруулах зорилгоор нөхөн төлбөрийг индексийн өөрчлөлтийн түвшинтэй уялдуулан шаталсан загвараар тооцно.

10.4. Нөхөн төлбөрийн хүснэгт нь даатгалын гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд индексийн босго, өөрчлөлтийн түвшин бүрд харгалзах нөхөн төлбөрийн хувь, төлбөрийн дээд хязгаар болон хэсэгчлэн, шаталсан байдлаар олгох нөхцөлийг агуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДААТГАЛЫН ХУРААМЖ, ГЭРЭЭ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

11 дүгээр зүйл. Даатгалын хураамж

11.1. Даатгалын хураамж нь эрсдэлийн түвшин, индексийн хэлбэлзэл, нөхөн төлбөрийн бүтэц, даатгалын дүнтэй уялдсан актуар тооцоонд үндэслэнэ.

11.2. Хураамж тогтоох, хэлэлцэх, баталгаажуулах зохицуулалтыг Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан холбогдох журмыг үндэслэн батална.

11.3. Даатгагчид бүтээгдэхүүний нөхцөл, хураамжийн гол үзүүлэлтийг нийтэд ил тод мэдээлнэ.

12 дугаар зүйл. Даатгалын гэрээ

12.1. Даатгалын гэрээнд Иргэний хууль, Даатгалын тухай хуульд зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана:

12.1.1. даатгуулах таримлын төрөл, тариалангийн талбай, хугацаа, даатгалын хамрах нэгж;

12.1.2. индексийн төрөл, мэдээллийн эх үүсвэр, тооцооллын тайлбар;

12.1.3. босго үзүүлэлт болон индексийн өөрчлөлтөөс хамааран нөхөн төлбөр тооцох хүснэгт;

12.1.4. даатгалын дүн, даатгуулагчийн өөрийн хариуцах эрсдэлийн хэмжээ;

12.1.5. тухайн төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн нэгжийн дундаж үнийн дүнгээс тооцох нөхөн төлбөрийн хувь;

12.1.6. нөхөн төлбөр олгох хугацаа, шилжүүлэх дансны мэдээлэл;

12.1.7. тариалангаа таван жил дараалан тогтмол даатгуулсан ч эрсдэлтэй нөхцөл гараагүй тул нөхөн төлбөр аваагүй даатгуулагчид үзүүлэх даатгалын хураамжийн хөнгөлөлтийн нөхцөл;

12.1.8. даатгуулагчид өгөх суурь зөрүүгийн талаарх тайлбар, мэдээлэл;

12.1.9. даатгуулагчийн зүгээс талбайдаа мэдрэгч төхөөрөмж байршуулах нөхцөл.

13 дугаар зүйл. Суурь зөрүү болон мэдээллийн үүрэг

13.1. Даатгагч суурь зөрүү үүсэх нөхцөл, түүний эрсдэлийг бууруулах үүднээс даатгалын нэгжийг нарийсгах, олон индекс ашиглах, хэсэгчлэн төлөх нөхцөл, аргыг харилцан тохиролцож гэрээнд тусган даатгуулагчид тайлбарлана.

13.2. Бодит хохирол гарсан боловч индексийн үзүүлэлт даатгалын тохиолдол гэж тооцогдох босгыг хангаагүй, эсхүл индексийн шалгуур хангагдсан ч бодит хохирлын хэмжээ бага байх нөхцөлийг даатгагч даатгуулагчид урьдчилан тайлбарлана.

14 дүгээр зүйл. Нөхөн төлбөр олгох

14.1. Тухайн эрсдэлийн индексийн албан ёсны мэдээлэл нийтэд зарлагдсан өдрөөс хойш гэрээнд заасан хугацаанд нөхөн төлбөрийг олгоно.

14.2. Нөхөн төлбөрийг тухайн эрсдэлийн газар дээрх бодит хохирлыг үл харгалзан зөвхөн индексийн албан ёсны мэдээлэлд үндэслэн олгоно.

14.3. Индексийн талаар маргаан гарсан нөхцөлд хяналт, шалгалт явуулж болно.

15 дугаар зүйл. Даатгуулагчийн эрхийг хамгаалах

15.1. Даатгагч нь даатгуулагчид дараах мэдээллийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр урьдчилан хүргэнэ:

15.1.1. индексийн утга, тооцооллын аргачлал; 15.1.2. болзошгүй суурь зөрүүгийн эрсдэл; 15.1.3. нөхөн төлбөр олгогдох болон олгогдохгүй нөхцөл.

15.2. Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүний үндсэн нөхцөл, эрсдэл, нөхөн төлбөрийн зарчим зэрэг суурь мэдээллийг товч, ойлгомжтой хэлбэрээр нэгтгэн харуулсан даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулгыг даатгуулагчид заавал хүргүүлнэ.

15.3. Даатгуулагчид шаардлагатай санхүүгийн боловсрол олгох сургалтыг холбогдох төрийн байгууллага, даатгагч хамтран зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЭРСДЭЛИЙН ХУВААРИЛАЛТ, ДАВХАР ДААТГАЛ, САНГУУД

16 дугаар зүйл. Эрсдэлийн хуваарилалт

16.1. Эрсдэлийг дараах байдлаар хуваарилна:

16.1.1. доод түвшний эрсдэл – даатгуулагч өөрийн хөрөнгөөр хариуцах;

16.1.2. дунд түвшний эрсдэл – даатгагчийн эрсдэлийн дунд түвшний сангаас;

16.1.3. дээд түвшний эрсдэл – эрсдэлийн дээд түвшний сан болон давхар даатгалаар.

17 дугаар зүйл. Хамтын эрсдэлийн сан

17.1. Хамтын эрсдэлийн сан нь давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.

17.2. Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулах журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

17.3. Хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо жил бүр тогтооно.

18 дугаар зүйл. Давхар даатгалын компани, олон улсын давхар даатгал

18.1. Тариалангийн индексжүүлсэн даатгалын дээд түвшний эрсдэлийг удирдах, олон улсын давхар даатгагчид даатгуулах шийдвэр гаргах, давхар даатгалын компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Даатгалын тухай хуулийн 14, 46-48 дугаар зүйлд, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

19 дүгээр зүйл. Давхар даатгалын компанийн сан

19.1. Давхар даатгалын компанийн сангийн төрөл, зориулалтыг энэ хуульд өөрөөр заагаагүй бол Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 25-27 дугаар зүйлд заасан зохицуулалтыг мөрдөнө. Давхар даатгалын компани тариалангийн индексжүүлсэн даатгалын чиглэлээр дараах бие даасан сантай байна:

19.1.1. дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан; 19.1.2. дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан; 19.1.3. алдагдлаас хамгаалах сан.

19.2. Эдгээр санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах хороо төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

20 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

20.1. Давхар даатгалын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүү, газар тариалан, статистик, онцгой байдал, цаг уурын өгөгдлийн байгууллага, даатгагч, даатгуулагчийн төлөөллийг оруулна.

20.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.2.1. бүтээгдэхүүний актуар тооцоолол, техникийн судалгаанд зөвлөмж гаргах;

20.2.2. сангуудын хөрөнгийг удирдах, захиран зарцуулах шийдвэр гаргах;

20.2.3. гэрээний загварыг батлах;

20.2.4. шаардлагатай тохиолдолд даатгагчид хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд тавих.

21 дүгээр зүйл. Нууцлал, мэдээллийн хамгаалалт

21.1. Албан үүргийнхээ дагуу олж мэдсэн нууцын зэрэглэлтэй баримт, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

22 дугаар зүйл. Тайлан, аудит, нийтэд мэдээлэх

22.1. Давхар даатгалын компанийн санхүүгийн тайланд аудит хийлгэнэ.

22.2. Жилийн тайлан, аудитын дүгнэлтийг нийтэд мэдээлнэ.

22.3. Олон улсын сайн туршлагад нийцүүлэн тодорхой хугацаанд олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар давтан аудит хийлгэж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦОО

23 дугаар зүйл. Төрийн дэмжлэг, татаас

23.1. Төрөөс тариалангийн индексжүүлсэн даатгалын хураамжийн тодорхой хувийг татаас хэлбэрээр санхүүжүүлж болно.

23.2. Татаасны хувь, хамрах хүрээ, зорилтот бүлгийг Засгийн газар батална.

23.3. Татаасыг хэрэгжүүлэхдээ хүртээмж, шударга байдал, төсвийн сахилга бат, ил тод тайлагналын зарчмыг баримтална.

23.4. Индексжүүлсэн даатгалд хамрагдсан тариаланчдыг төрөөс олгох дэмжлэг, урамшуулалд нэн тэргүүнд хамруулна.

24 дүгээр зүйл. Өгөгдөл, дэд бүтцийн дэмжлэг

24.1. Индексжүүлсэн даатгалын найдвартай, тогтвортой ажиллагааг хангах зорилгоор индекс тооцоход ашиглагдах цаг уурын ажиглалтын сүлжээ, зайнаас тандан судлалын мэдээлэл, ургацын статистикийн чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээг төрөөс дэмжинэ.

24.2. Тариалангийн индексжүүлсэн даатгалд шаардлагатай хэмжилт–тайлагнал–баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл. Хяналт тавих

25.1. Энэ хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох шатны Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

26 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх

26.1. Энэ хуулиар зохицуулаагүй даатгалын гэрээ, үйлчилгээ, гомдол, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг Даатгалын тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

26.2. Индексийн мэдээлэл, тооцооллын маргаанд хараат бус эксперт/аудитын дүгнэлт гаргуулах боломжийг журамд тусгана.

27 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

28 дугаар зүйл. Шилжилтийн үе шатны зохицуулалт

28.1. Энэ хуулийн хэрэгжилтийг хангахдаа дараах үе шат, зарчмыг баримтална:

28.1.1. туршилтын аймаг, суманд хэрэгжүүлэх;

28.1.2. эхний ээлжид эрсдэлийн үнэлгээ, өгөгдлийн бэлэн байдал хангагдсан таримал, индексийн төрлөөр хэрэгжүүлж, улмаар таримлын нэр төрөл болон индексийн төрлийг үе шаттайгаар өргөжүүлэх;

28.1.3. санхүүгийн татаасыг аажмаар бууруулж, зах зээлийн механизмд шилжих.

28.2. Туршилтын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй байх;

28.3. Туршилтын хугацааны хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг энэ хуулийн 28.2 дахь хэсэгт заасан шалгуураар үнэлж, үнэлгээний дүнд үндэслэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

29 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

29.1. Энэ хууль ___ оны ___ дугаар сарын ___-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөнө.

Гарын үсэг